МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 10 өдөр Дугаар А/51 Мөрөн сум

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны А/190, А/280 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ын 1.3, 3.3, 3.4 дэх хэсгүүдийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Хорооны дарга:
Аймгийн Засаг даргын орлогч

Хорооны гишүүд:
Аймгийн Шүүхийн Тамгын газрын дарга
Аймгийн Ерөнхий прокурор
Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга
Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга
Цагдаагийн газрын дарга
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга
Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга
Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга
Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга
Монголын өмгөөлөгчдийн холбооны Хөвсгөл аймаг дахь салбар зөвлөлийн дарга /зөвшилцсөнөөр/
Гэр бүл, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/

Хорооны нарийн бичиг бөгөөд ажлын албаны дарга:
Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга

2. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Хүүхдийн төлөө зөвлөлд хагас, бүтэн жилээр ажлаа тайлагнаж ажиллахыг хорооны дарга (М.Хуягбаатар), нарийн бичиг (Ч.Дашбаяр) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/736 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ш.ИДЭРБАЯСГАЛАН